Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлийн бакалаврын хөтөлбөрийн өнөөгийн байдал, чанар, үр дүн

У.Мягмаржав[1], Б.Мядагмаа[2], О.Болорсайхан[3]

[1]Боловсролын хүрээлэн
[2]Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
[3]АШУҮИС, ЧБА.
Цахим хаяг: myagaa.edu@gmail.com, Утас: 99087099

Түлхүүр үг:
Хөтөлбөрийн чанар
Үр дүн
Үнэлгээ
Анагаах ухаан

Товч утга:
Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө 2021-2030 баримт бичигт “Сургуулийн үйл ажиллагааны үр дүн, чанарыг үнэлэх аргачлал нь зөвхөн “үр дүн” бус мөн “үйл явц”, суралцагчдын гүйцэтгэл ба сурлагын амжилт, суралцахуйн ач холбогдлыг чухалчлан авч үзэж буй хандлагыг онцлон тэмдэглэсэн байна. Эдгээрийг үндэслэн анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа сургуулиудад ийм төрлийн судалгаа хомс хийгдсэн тул бид энэхүү судалгааг анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлийн бакалаврын хөтөлбөрийн өнөөгийн байдал, хөтөлбөрийн боловсруулалт, үр дүн, чанарыг үнэлэх зорилгын хүрээнд хийж гүйцэтгэсэн.

Үндэслэл: Монгол Улсын дунд хугацааны (2020-2025) тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл 5-ын зорилт 2-т “Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан, технологийн дэвшил, иргэдийн сурах хэрэгцээ, ажлын байранд тавих шаардлагатай уялдуулан тасралтгүй хөгжүүлнэ” гэж заасан байна.

Боловсролын салбарын эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх нөхцөлийг бүрдүүлэх, сайжруулах талаар тусгасан байна.


Их дээд сургуулийг төгсөгчдийн ажил эрхлэлт, салбарын үр өгөөж, нийгэмд эзлэх тухайн сургуулийн нэр хүнд гэсэн гурван гол үзүүлэлтээр үнэлдэг тул доорхи зорилго, зорилтыг дэвшүүлэн судалгааг хийж гүйцэтгэсэн.

Зорилго: Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлийн бакалаврын хөтөлбөрийн өнөөгийн байдал, хөтөлбөрийн боловсруулалт, үр дүн, чанарыг үнэлэх

Зорилт:
1. Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн өнөөгийн байдлыг судлах
2. Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн боловсруулалтанд үнэлгээ хийх
3. Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн, чанарыг үнэлэх


Судалгааны материал, арга зүй: Тоон болон чанарын судалгааны аргаар болон хөндлөнгийн үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ зэргээр судалгааг хийж гүйцэтгэсэн. Мэдээ материалыг статистик мэдээ, тайлан болон баримт бичгийн судалгааны аргаар цуглуулав.

Үр дүн:
1. Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн өнөөгийн байдал: Монгол Улсад Анагаахын ухааны чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчийн 1, хувийн өмчийн 11, нийт 12 сургууль байна.



Зураг 1. Бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сургуулиудын тоо

Бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургуулийг харьцуулж үзэхэд 83.3 хувь нь сувилахуй, 58.3 хувь нь анагаах ухаан, 58.3 хувь нь эм зүй, 41.6 хувь нь уламжлалт анагаах ухаан, 33.3 хувь нь нүүр ам судлал, 25 хувь нь хөдөлгөөн засал, 25 хувь нь нийгмийн эрүүл мэнд, 16.6 хувь нь эх барихуй, 16.6 хувь нь био-анагаах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Харин бусад хөтөлбөр нь тус бүр 8.3 хувьтай байна. (Зураг 1)




Зураг 2. Хөтөлбөрөөр суралцагч, төгсөгч /2017-2018 он/

Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр 2017-2018 оны хичээлийн жилд 16525 суралцагчаас анагаах ухаан 6983, сувилахуй 2029 суралцагч суралцаж, байна. Нийт 3185 төгсөгчийн 32.5% анагаах, 17.77% нь сувилахуйгаар төгссөн байна. (Зураг 2)

2. Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн боловсруулалтыг үнэлэх

А. Хөтөлбөрийн баримт бичгийн боловсруулалтад хийсэн үнэлгээ:

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” А/78, А/174 тоот тушаалыг үндэслэн баримтын судалгааг гүйцэтгэсэн. Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн боловсруулалтыг үнэлэхэд нийт 28 хөтөлбөр хамрагдсанаас анагаахын чиглэлийн 22 хөтөлбөр, үүнээс хамгийн олон хөтөлбөр нь сувилахуйн 7 (31.8%) хөтөлбөр хэрэгжиж байна.




Зураг 3. Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлийн хөтөлбөрийн боловсруулалтад хийсэн үнэлгээ

Үнэлгээнээс харахад Анагаах, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй 22 хөтөлбөрийн 8 нь 90-100 хувьтай, 6 нь 80-89 хувьтай, 3 нь 70-79 хувьтай, 3 нь 60-69 хувьтай, 2 нь 59 хувиас доош үнэлэгдсэн байна. (Зураг 3)

3.Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрөөр суралцагч, төгсөгчийн хөндлөнгийн үнэлгээ, чанарыг үнэлэх

А. Суралцагчдын хөндлөнгийн үнэлгээ:

2019 онд Боловсролын үнэлгээний төвөөс Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын мэдлэгийг ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн агуулгад нийцүүлэн хөндлөнгийн үнэлгээ хийхээр “Анагаах ухаан”, “Нүүр ам судлал”, “Уламжлалт анагаах ухаан”, “Эм зүй”, “Сувилахуй”, “Эх барихуй” хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэж буй хот, хөдөөгийн 13 их, дээд сургуулийн 3086 суралцагчийг хамруулан шалгалтыг нэгдмэл агуулгаар авсан.



Зураг 4. Суралцагчдын хөндлөнгийн үнэлгээ

Уг судалгааны үр дүнгээс харахад Суралцагчдын хөндлөнгийн (гүйцэтгэлийн) үнэлгээний хувь Улаанбаатар хотод 41.5 хувь, хөдөө орон нутагт 47.1 хувийн амжилттай байв.

Суралцагчийн үнэлгээнээс хөтөлбөрийн чанар, явцын үнэлгээг хийх боломж бүрдэж байна. (Зураг 4)

Б.Төгсөгчдийн үнэлгээ

Хүснэгт 2. Төгсөгчдийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шалгалтын нэгдсэн дүн

Он		2015	2016	2017	2018	Жилийн дундаж
Нийт төгсөгч		2950	3244	3161	3095	3113
Шалгалт	орсон	2810	3139	2940	2874	2941
	ороогүй	140	105	136	221	151
	тэнцсэн	1099	2171	2175	2552	1999
	тэнцээгүй	1711	970	765	322	942
Амжилт		39.1%	69.2%	73.9%	88.7%	68%

2015-2018 оны 4 жилийн дунджаар төгсөгчид 3113, үүний 68 хувь нь үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шалгалтанд тэнцсэн, төгсөгчдийн амжилт жил бүр нэмэгдэх хандлагатай байна.

В. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл

Хүснэгт 3. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл

№	Хөтөлбөрийн тоо	Олон улсын магадлан итгэмжлэл	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл
Тоо	54	1	10
Хувь	100%	1.85%	18.5%

Анагаах ухааны чиглэлээр бакалаврын сургалт эрхэлж буй 54 хөтөлбөрийн 10 нь буюу 18.5 хувь нь үндэсний хэмжээнд, 1 хөтөлбөр буюу 1,85% нь олон улсад анх удаа магадлан итгэмжлэгдсэн байна.

Хэлцэмж: Сургуулиуд хөтөлбөрүүдээ үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэх үйл явцыг идэвхжүүлэх, сургууль бүрд чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэх, бэхжүүлэх, хөгжүүлэхэд анхаарал хандуулж их, дээд сургууль, коллежиуд чанараа зөвхөн хөндлөнгөөр үнэлүүлэх биш, өөрөө дотооддоо үнэлж, сайжруулдаг ажлыг хэвшүүлэх чиглэлээр ажиллаж байгаа давуу талтай байна.

Дүгнэлт:

1. Анагаах ухаан, эрүүл мэндийн чиглэлийн бакалаврын хөтөлбөрийн 83.3% нь сувилахуй, 58.3% нь анагаах ухаан байгаа боловч төгсөгчдийн 32.5% анагаах, 17.77% нь сувилахуйгаар төгссөн байна.
2. Судалгаанд хамрагдсан сургалтын хөтөлбөрийн 36 хувь нь хангалттай сайн боловсруулалттай, 20 орчим хувь нь хангалтгүй боловсруулалттай байна.
3. Суралцагчдын гүйцэтгэл дунджаар 44,3%, төгсөгчдийн тусгай зөвшөөрлийн шалгалт 68%, төгсөгчдийн ажил эрхлэлт 70,8% (үүнээс их эмчээр төгсөгчдийн 40%, сувилагчаар төгсөгчдийн 94%) байна. Бакалаврын 54 хөтөлбөрийн 18.5% нь үндэсний хэмжээнд, 1,85% нь олон улсад магадлан итгэмжлэгдсэн байна.

Цаашид анхаарах зүйлс:

1. Анагаахын чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулж буй сургуулийн ангилал, тусгай зөвшөөрлийн мэргэжлийн чиглэлээр элсэлт авах, хяналтын тоог баримтлах;
2. БШУ-ы сайдын А/174 тоот тушаалаар баталсан бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын дагуу сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах;
3. Хөтөлбөрийг гадаад, дотоодын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа дутмаг байгаа тул цаашид судалгааг хийж, хөтөлбөрийн шинэчлэл хийхдээ тусгах;
4. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, ажил олгогчдын судалгаа, санхүүгийн эрсдлийн үнэлгээ зэргийг хөтөлбөрийн боловсруулалтад тусгах;
5. Цахим хичээл, цахим мэдээллийн санг баяжуулж, ном, сурах бичгийг хөтөлбөрт тусгах, уян хатан сонголттой зохион байгуулах;

Талархал: Энэхүү судалгааны ажлыг хийхэд хамтран ажилласан, ажиллах нөхцөл боломжоор хангасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын бодлогын газар, Боловсролын хүрээлэн, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба, төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежууд болон багш судлаачдадаа гүн талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *(2016) Монгол Улсын Засгийн газрын тухай хууль*
2. *(2002) Боловсролын тухай хууль*
3. *(2019) Монгол Улсын дунд хугацааны (2020-2025) тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл (тайлан III)*
4. *(2010) Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Сайдын А/26 дугаар тушаал*
5. *(2014) Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын А/174 дүгээр тушаал*
6. *(2014) Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын А/78 дугаар тушаал*
7. *(2017) Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Сайдын А/103 дугаар тушаал*
8. *(2018) Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Сайдын А/533 дугаар тушаал*
9. *(2019) Мягмаржав,У. & М.Энхээ (2019). Монгол улсад сургалтын үйл ажиллагаа эрхэлж буй зарим их, дээд сургуулиудын бакалаврын хөтөлбөрт хийсэн хөндлөнгийн үнэлгээний үр дүн. Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг № 24.*

Current status, quality and outcome of bachelor programm in medical science and health fields

U.Myagmarjav[1], B.Myadagmaa[2], O.Bolorsaikhan[3]

[1]EDU
[2]MNCEA
[3]QA,MNUMS
Email:myagaa.edu@gmail.com, Tel: 99087099

The methodology to evaluate educational operation outcome and quality shall focus not only in “results” but also “in process. hence the importance of student performance and educational achievements during studies in highlighted in the 2021-2030 educational medium-term development plan document. We have conducted this research to assess current status, curriculum development, outcome and quality of bachelor curriculums of medical science and health fields as well as taking into considerprocessation lack of such research executed by medical science educational organizations.